



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Г Компанийн 2024 оны санхүүгийн тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.
2. Хараат бус аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж тухай бүр тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д даалгасугай.
3. Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525617040



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Гишүүнчлэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20 дах заалт, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.3.1, 7.1.3.5, "Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

1. "Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүнчлэлээс хассугай.
2. Гишүүнчлэлээс хассантай холбогдуулан мэдээллийн санд зохих өөрчлөлт оруулах, олон нийтэд мэдээлэх, холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. "Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийг гишүүнчлэлээс хассантай холбоотойгоор гишүүнчлэлийн хөлсний үлдэгдэл, бусад тооцоог барагдуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ТОГТОХБАЯР



1525613047



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Г

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1.2, 92 дугаар зүйлийн 92.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.16, "Арилжааны журам"-ын Хавсралт 1-ийн 6 дахь заалт, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 22.10 дахь заалт, Аудитын хорооны 2025 оны 04 сарын 01-ний өдрийн ... дугаартай дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор Сангийн яамтай "Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-г байгуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д олгосугай.
2. "Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-нд анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийн хэмжээг худалдагч талаас 0.03-0.06 хувийн хооронд, худалдан авагч талаас 0-0.00875 хувийн хооронд байхаар, үнэт цаас гаргагчаас үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс авахгүй байхаар тус тус үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцож тусган, арилжааны бэлтгэл ажлыг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ТОГТОХБАЯР



1525613051